

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 06-р сарын 07-ны өдөр

№ 4/20-Т

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай “Инвескор ББСБ” ХХК (“Компани” гэх)-ийн Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дах хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3, болон 76 дугаар зүйлийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**


1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (“Хурал” гэх)-ыг 2019 оны 07-р сарын 25-ны өдрийн 14:00 цагт Монгол Улс, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Гандигийн гудамж-39, Корпорейт хотел энд Конвеншн центрын “Ивент Холл”-д зарлан хуралдуулсугай;
2. Энэхүү тогтоолыг баталсан тухай мэдэгдлийг 2019 оны 06-р сарын 10-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д хүргүүлсүгэй;
3. “Хурлын зарын загвар”-ыг энэхүү тогтоолын Нэгдүгээр Хавсралтаар баталж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг телевиз, Компани болон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн цахим хуудсаар дамжуулан 2019 оны 06-р сарын 12-ны өдөр нийтэд мэдээллэж, зарын давталтыг 2019 оны 06-р сарын 28-ны өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээллэсүгэй;
4. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 07-р сарын 01-ний өдрөөр тасалбар болгон тогтоосугай;
5. “Хурлаар хэлэлцэх асуудлууд”-ыг энэхүү тогтоолын Хоёрдугаар Хавсралтаар баталсугай;
6. “Хурлын санал авах хуудас”-ын загварыг энэхүү тогтоолын Гуравдугаар Хавсралтаар баталсугай;
7. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2019 оны 06-р сарын 17-ны өдрийн дотор үнэт цаасны брокер, дилерийн компаниудад хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /О.Уянга/-д үүрэг болгосугай;
8. Хурлын даргаар “Инвескор ББСБ” ХХК-ийн Гүйцэтгэх захирал /Д.Баясгалан/-г томилсугай;
9. Дараах нэр бүхий хүмүүсийг Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Хурал зохион байгуулах комиссын дарга:
Хурал зохион байгуулах комиссын гишүүд:

Р.Мөнхтөр /Борлуулалт, маркетингийн газрын дарга/
Д.Оролмаа /Бизнес хөгжлийн ахлах менежер/;
Э.Болорцэцэг /Салбарын удирдлага хариуцсан ахлах менежер/
А. Энэрэл /Санхүүгийн ахлах менежер/
Б. Хөлгэн /Бизнес хөгжлийн мэргэжилтэн/
Б.Мөнх-Эрдэнэ /Оффис менежер/

10. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай.
Үүнд:
- | | |
|----------------------------|---|
| Тооллогын комиссын дарга: | С. Батчимэг /"Ти Ди Капитал ҮЦК" ХХК/ |
| Тооллогын комиссын гишүүд: | Г. Маргад /"Ти Ди Капитал ҮЦК" ХХК/
Б. Энхмарал /"Инвескор капитал ҮЦК" ХХК/ |
11. Компанийн бүртгэгдсэн хувьцаа эзэмшигчдэд Хурлыг зарыг нийтэд мэдээллэсэн өдрөөс эхлэн Компанийн төв оффист ирж Хурлаар хэлэлцэх асуудал, түүнтэй холбоотой баримт бичигтэй танилцах боломжийг бүрдүүлэхийг Гүйцэтгэх захирал /Д. Баясгалан/ болон Хурал зохион байгуулах комисс /Р. Мөнхтөр/-д даалгасугай.
12. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Хурлыг зарыг нийтэд мэдээллэж, бүрэн дүүрэн, түргэн шуурхай гүйцэтгэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисс /Р. Мөнхтөр/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА





Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06-р сарын 07-ны өдрийн хурлын 1805 тогтоолын Нэгдүгээр хавсралт

**“ИНВЕСКОР ББСБ” ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ЗАР**

Компанийн нэр:	Инвескор ББСБ ХХК
Хурлын төрөл:	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал
Хурал хуралдах өдөр, цаг:	2019-07-25-ны өдөр, 14:00 цаг
Хурал хуралдах газар:	Монгол Улс, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Гандигийн гудамж-39, Корпорейт Хотел энд Конвеншн Центрын “Ивент Холл”-д
Бүртгэлийн өдөр:	2019-07-01-ний өдөр
Зарлах өдөр:	2019-06-12-ны өдөр
Зарлуулсан эх сурвалж:	2019-06-12-ны өдөр “Инвескор ББСБ” ХХК болон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн цахим хуудсанд байршуулах, өдөр тутмын “Өдрийн сонин”-д хэвлүүлэх, олон нийтийн телевизээр болон олон нийтийн сүлжээгээр зарлах
Хурлаар хэлэлцэх асуудал:	-2019 оны хагас жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг тайлагнах; -Компанийн “Дүрэм”-ийн төслийг батлах; -Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох; -Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны төсөв батлах
Хурал хуралдах шийдвэр гаргасан этгээд, шийдвэрийн огноо, дугаар:	Төлөөлөн удирдах зөвлөл, 2019-06-07, №А/20-Т
Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн:	Хурлын дарга Р.Мөнхтөр, гишүүд Д.Оролмаа, Э.Болорцэцэг, А. Энэрэл, Б.Хөлгэн, Б. Мөнх-Эрдэнэ
Холбоо барих утасны дугаар:	7709 0077



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06-р сарын 07-ны өдрийн хурлын 1107 тогтоолын Хоёрдугаар хавсралт

**“ИНВЕСКОР ББСБ” ХХК-ИЙН 2019 ОНЫ 07-Р САРЫН 15-НЫ ӨДӨР ХУРАЛДАХ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ**

1. 2019 оны хагас жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. Компанийн “Дүрэм”-ийн төслийг батлах;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны төсөв батлах.



**“ИНВЕСКОР ББСБ” ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС
Хэлэлцэх асуудал № 2,4**

Хувьцаа эзэмшигчийн овог: _____ Нэр : _____
Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар: _____
Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн
Эзэмшиж буй хувьцааны тоо: _____ үсгээр _____
Бүртгэсэн Брокер, дилерийн компанийн нэр _____
Бүртгэсэн Брокерийн овог, нэр _____

Энэхүү Санал авах хуудсаар 2019 оны 07-р сарын 25-ны өдрийн 14:00 цагт Монгол улс, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Гандигийн гудамж-39, Корпорейт Хотел энд Конвеншн Центрын “Ивент Холл”-д хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд санал өгнө.

№	Хэлэлцэх асуудлууд	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	Компанийн “Дүрэм”-ийн төслийг батлах	Тогтоол №1			
2.	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны төсвийг батлах	Тогтоол №3			

Брокер _____ /гарын үсэг/
_____ /тамга/

Хувьцаа эзэмшигч _____ /гарын үсэг/
_____ /тамга/

Санал авах хуудсыг ашиглах санаамж:

1. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол үнэт цаасны компани дээр очиж хурлын материалтай танилцаж санал авах хуудсаар саналаа өгнө.
2. Засварласан болон балласан залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
3. Санал авах хуудас хүчингүйд тооцсон тухай шалтгааныг энд дурьдана уу

2019 оны _____-р сарын _____-ны өдөр



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 06-р сарын

07-ны өдрийн хурлын АХТ тогтоолын Гуравдугаар хавсралт

1116224289 6060854

**“ИНВЕСКОР ББСБ” ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС
Хэлэлцэх асуудал №3**

Хувьцаа эзэмшигчийн овог: _____ Нэр : _____

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: Энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____ Кумулятив _____

Саналын тоо: _____

Бүртгэсэн Брокер, дилерийн компанийн нэр _____

Бүртгэсэн Брокерийн овог, нэр _____

Энэхүү Санал авах хуудсаар 2019 оны 07-р сарын 25-ны өдрийн 14:00 цагт Монгол Улс, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Махатма Гандигийн гудамж-39, Корпорейт Хотел энд Конвеншн Центрын “Ивент Холл”-д хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд санал өгнө.

№	ТУЗ-Д НЭР ДЭВШИГЧДИЙН НЭРС	НЭР ДЭВШИГЧДЭД ӨГӨХ САНАЛЫН ТОО
Тогтоол №2		
Ердийн гишүүд:		
1.		
2.		
3.		
4.		
5.		
6.		
7.		
Хараат бус гишүүд:		
1.		
2.		
3.		
4.		

Брокер _____ /гарын үсэг/
_____ /тамга/

Хувьцаа эзэмшигч _____ /гарын үсэг/
_____ /тамга/

Санал авах хуудсыг ашиглах санамж.

- Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол үнэт цаасны компани дээр очиж хурлын материалтай танилцаж санал авах хуудсаар саналаа өгнө.
- Засварласан болон балласан залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
- Санал авах хуудас хүчингүйд тооцсон тухай шалтгааныг энд дурьдана уу.

2019 оны _____-р сарын _____-ны өдөр

ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана. Тус арга нь санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. Жишээ нь: та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байхад үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон тохиолдолд Хувьцаа эзэмшигч эзэмшиж буй 10 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 90 саналын эрхтэй /10*9 гишүүн=90/ болох бөгөөд үүнээс 60 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 30 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болно гэдгийг анхаарна уу.